

**МОНГОЛ УЛСЫН МЯНГАНЫ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТОД СУУРИЛСАН  
ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ЦОГЦ БОДЛОГЫН  
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

/2015 оны жилийн эцсийн байдлаар/

№	Үе шат	Стратегийн зорилт	Бодлогын баримт бичигт тусгагдсан байдал		Хэрэгжүүлэх байгууллага	Биелэлт	Яам, агентлагийн үнэлгээ	...-НЫ үнэлгээ	...-НЫ үнэлгээ ний тайлбар
			ЗГҮАХ	ЭЗНХҮЧ					
<b>5.3.5. Хот байгуулалт, барилгын хөгжлийн бодлого</b>									
1	Бүх үе шат (2007-2021 он:	<p><b>Стратегийн зорилт 4.</b> Хот суурингийн газар ашиглалтыг сайжруулж, эд хөрөнгийн бүртгэлийн тогтолцоо, үйл ажиллагааг боловсронгуй болгоно.</p> <p><b>Хэрэгжүүлэх арга хэмжээ:</b> Үл хөдлөх эд хөрөнгийг эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд бүрэн хамруулж, өмчийн бүртгэлийн системийг боловсронгуй болгон бэхжүүлэх.</p>	-	-	УБЕГ	<p>Монголын Мянганы сорилтын сангийн “Хөрөнгийн эрхийн төсөл”-ийн хүрээнд нийслэлийн 9 дүүрэг болон, 8 аймаг /Дархан-Уул, Дорнод, Орхон, Өвөрхангай, Завхан, Ховд, Хэнтий, Төв/-ийн эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлж, нэгдсэн сүлжээнд холбон, ePRS системийг нэвтрүүлсэн.</p> <p>2014 онд өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан Сэлэнгэ аймгийн Сайхан, Мандал, Баянгол, Сант, Орхон, Орхонтуул, Баруунбүрэн сумын эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн архивын баримтыг бүрэн цахимжуулж, мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбон дээрх сумдыг бүсчлэн Сайхан, Мандал сумаас эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн үйлчилгээг үзүүлж эхэлсэн.</p> <p>2015 онд Баянхонгор, Өмнөговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлыг тухайн аймаг, орон нутгийн дэмжлэгтэйгээр бүрэн дуусгаж, ePRS системийг нэвтрүүлэн бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байна.</p> <p>Бусад аймгийн эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн архивын нотлох баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх, эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн ePRS системийг нэвтрүүлэх арга хэмжээг Дэлхийн банкнаас хэрэгжүүлэх “Ухаалаг засаг” төсөлд тусган, Улсын Их Хурлаар батлуулан, 2016 оноос уг төслийг хэрэгжүүлж эхлэхээр бэлтгэж байна.</p>	100%		

						<p>Хүн амын төвлөрөл ихтэй Завхан аймгийн Тосонцэнгэл сум, Өмнөговь аймгийн Даланзадгад сум, Төв аймгийн Лүн сумдад эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн ePRS системийг нэвтрүүлэн, эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн бүх төрлийн үйлчилгээг үзүүлж байна.</p> <p>Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай хуульд хүн ам, орон сууцны ээлжит тооллогыг 2010 оноос эхлэн 10 жил тутам, завсарын тооллогыг ээлжит тооллого хооронд 5 жил тутам зохион байгуулахаар заасан байдаг.</p> <p>Үндэсний статистикийн хорооноос 2010 онд зохион байгуулагдсан тооллогоор Монгол Улсад 382808 байшин /орон сууц, хувийн сууц/ тоологдсон байна. 2015 оны хүн ам, орон сууцны тооллогын дүн одоогоор гараагүй байна.</p> <p>2015 оны жилийн эцсийн байдлаар 472207 үл хөдлөх эд хөрөнгө, 317974 газар улсын бүртгэлд бүртгэлтэй байна.</p>			
<b>7.Эрх зүй, төрийн байгуулалын хөгжлийн бодлого</b> <b>7.2. Монгол Улсын төрийн байгуулал, төрийн удирдлагын хөгжил</b>									
2	Бүх үе шат (2007-2021 он)	<p><b>Стратегийн зорилт 5.</b> Төрийн бүртгэл, мэдээллийн тогтолцоог шинэтгэж, бодитой, үнэмшилтэй цахим мэдээллийн тогтолцоо, сан байгуулна.</p> <p><b>Хэрэгжүүлэх арга хэмжээ:</b> 1.Төрийн бүртгэлийг цахим хэлбэрт бүрэн шилжүүлж, төрийн бүртгэлд бүртгүүлснийг батлах баримт</p>	-	-	МШХХТГ УБЕГ	<p><u>Иргэний бүртгэлийн чиглэлээр:</u></p> <ul style="list-style-type: none"> <li>➢ Иргэний шинэчилсэн бүртгэлийн ажлыг зохион байгуулж, Монгол Улсын иргэдийн биеийн давхцахгүй өгөгдлийн мэдээллийн санг үүсгэж, иргэний цахим үнэмлэхийг олгосон.</li> <li>➢ Улсын хэмжээнд иргэний бүртгэлийн цахим мэдээллийн нэгдсэн санг үүсгэж, онлайн, офлайн програм хангамжийг нэвтрүүлэн аймаг, нийслэл, сум, дүүрэг, хорооны хэмжээнд эрхлэн хөтөлж байна.</li> <li>➢ Иргэний цахим үнэмлэхийг ашиглан Төрийн үйлчилгээний цахим машинаас иргэний бүртгэл, эд хөрөнгийн эрхийн бүртгэл, хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр 10 төрлийн лавлагаа, үйлчилгээ, Татварын ерөнхий газрын 4 төрлийн лавлагаа, Нийгмийн даатгалын лавлагаа, Гаалийн байгууллагад өртэй эсэх лавлагаа, Цахилгааны төлбөр төлөх үйлчилгээг авдаг болсон.</li> </ul>	100%		

		<p>бичгийг компьютерт уншигдахаар болгон, бусад төрлийн цахим баримт бичигтэй хоршин хэрэглэдэг болгох.</p>				<ul style="list-style-type: none"> <li>➤ Иргэний баримтын архивын цаасан суурьт баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын явц 88.05%-ийн гүйцэтгэлтэй байна.</li> <li>➤ Тус газрын даргын 2015 оны 1059 дүгээр тушаалаар “Төрсний бүртгэлд бүртгүүлэх хүсэлтийг цахим хэлбэрээр хүлээн авах, бүртгэл хөтлөх журам”-ыг батлаад байна. Эрүүл мэндийн яамны төрөлт, нас баралтын нэгдсэн санг тус газрын мэдээллийн сантай холбох чиглэлээр “Эх болон нялхсын эндэгдлийн бүртгэлийг сайжруулах төсөл”-ийн хүрээнд Эрүүл мэндийн яамтай хамран ажиллаж байна. Тус газрын мэдээллийн санг дээрх мэдээллийн сантай холбож, Цахим гарын үсгийн тухай хуульд заасан тоон гарын үсэг хэрэгжиж эхэлснээр төрсний бүртгэлд бүртгүүлэх хүсэлтийг цахимаар хүлээн авч, бүртгэх боломж бүрдэнэ.</li> <li>➤ Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 289 дүгээр тогтоолоор батлагдсан “Агаарын тээврийг хялбаршуулах үндэсний хөтөлбөр”-т тусгагдсан цахим /чиптэй/ гадаад паспортыг хэрэглээнд нэвтрүүлэх чиглэлээр дараах ажлуудыг хийж байна: <ul style="list-style-type: none"> <li>• Гадаад хэргийн сайдын 2015 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн А/64 дүгээр тушаалаар “Монгол Улсын үндэсний цахим гадаад паспортын загвар”-ыг баталсан;</li> <li>• Тус газраас “Монгол Улсын үндэсний энгийн гадаад паспорт олгох, эзэмших, хадгалах журам”-ын шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, Хууль зүйн яаманд хүргүүлсэн;</li> <li>• Хууль зүйн яамнаас сонгон шалгаруулсан цахим гадаад паспортын бэлдэцийг нийлүүлэх компанитай гэрээ байгуулах бэлтгэл ажлыг хангаж байна.</li> </ul> </li> <li>➤ Иргэний цахим үнэмлэхийн бичил санах ойд шилжилт хөдөлгөөний мэдээллийг бичих, иргэний цахим үнэмлэхийн бичил санах ойгоос</li> </ul>			
--	--	---	--	--	--	--	--	--	--

					<p>бичвэр, зурган мэдээллийг унших боломжтой шийдлийг боловсруулан, “Монгол Улсын иргэний цахим үнэмлэхийн бичил санах ойд мэдээлэл оруулах картын загвар, тодорхойлолт”-ыг боловсруулан УБЕГ-ын даргын 2015 оны 1750 дугаар тушаалаар баталж, аймаг, дүүрэг, сум, хорооны нэгж, албан хаагчдад иргэний үнэмлэх уншигч, бичигч төхөөрөмжийг тарааж, иргэний үнэмлэхэд бичилт хийх програм хангамжийг суулган, хаягийг цахим үнэмлэхэд далд бичих үйлчилгээг нэвтрүүлсэн.</p> <p><u>Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн чиглэлээр:</u> Нийслэл болон 11 аймгийн эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлыг гүйцэтгэж, улсын хэмжээнд нэгдсэн шинэ систем /ePRS/-д холбон, үйл ажиллагаандаа ашиглаж байна.</p> <p>Эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээ нь дахин давтагдахгүй бар код бүхий нууцлалтай болж тухайн гэрчилгээг бар код уншигчийн тусламжтайгаар ямар өмчлөгчид хэзээ олгосоныг таних боломжтой болсон.</p> <p><u>Хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр:</u> Хуулийн этгээдийн бүртгэлийн архивын баримтыг улсын хэмжээнд 100% цахим хэлбэрт шилжүүлж, нийслэл болон 21 аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийг холбосон нэгдсэн сүлжээ, шинэ програм хангамжийг бий болгосон.</p> <p>Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдаж, 2015 оны 3 дугаар сарын 1-ний өдрөөс мөрдөгдөж эхэлсэнтэй холбогдуулан хуулийн этгээдийн мэдээллийг цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлэх портал сайт болон хуулийн этгээдийн нэрийг онлайнаар шинээр авах, хуулийн этгээдийг шинээр үүсгэн байгуулах, хуулийн этгээдийн мэдээлэлд нэмэлт өөрчлөлт оруулах, үйлчилгээний</p>		
--	--	--	--	--	--	--	--

						дарааллыг урьдчилан захиалах хүсэлт хүлээн авах, хуулийн этгээдийн гэрчилгээг онлайнаар харах агуулга бүхий үйлчилгээний вэб портал бий болгож, хэрэглээнд нэвтрүүлсэн. Тайлангийн хугацаанд байгууллагын <a href="https://burtgel.gov.mn/">https://burtgel.gov.mn/</a> цахим хуудсаар дамжуулан хуулийн этгээдийн нэр захиалах 3908, нэрийн баталгаажуулалт 372, хуулийн этгээдийн мэдээлэлд өөрчлөлт оруулах 9, хуулийн этгээд шинээр үүсгэн байгуулах 146 хүсэлтийг цахим хэлбэрээр хүлээн авч, бүртгэлийн үйлчилгээг үзүүлсэн.			
3		2.Иргэний баримт бичгийг цахимжуулах.	-	-	УБЕГ МШХХТГ	<p><b>Иргэн, хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн баримт бичгийг цахимжуулах ажлын хүрээнд:</b></p> <p>Монголын Мянганы сорилтын сангийн “Хөрөнгийн эрхийн төсөл”-ийн хүрээнд нийслэлийн 9 дүүрэг болон, 8 аймгийн эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн архивын 14934001 хуудас баримт, 2014 онд өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан Сэлэнгэ аймгийн Сайхан, Мандал, Баянгол, Сант, Орхон, Орхонтуул, Баруунбүрэн сумын эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн 432605 хуудас баримт, 2015 онд Баянхонгор, Өмнөговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн архивын 875539 хуудас баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлыг тухайн аймаг, орон нутгийн дэмжлэгтэйгээр бүрэн дуусгаж, ePRS системийг нэвтрүүлэн бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байна.</p> <p>Нийт эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн 16.242.145 хуудас архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлээд байна.</p> <p>Бусад аймгийн эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн архивын нотлох баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх, эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн ePRS системийг нэвтрүүлэх арга хэмжээг Дэлхийн банкнаас хэрэгжүүлэх “Ухаалаг засаг” төсөлд тусган, Улсын Их Хурлаар батлуулан, 2016 оноос уг төслийг хэрэгжүүлж эхлэхээр бэлтгэж байна.</p> <p>БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага /КОЙКА/-тай хамтран Иргэний</p>	100%		

						<p>баримтын архив, хуулийн этгээдийн бүртгэлийн архивын баримтыг цахимжуулах ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулж байна.</p> <p>Иргэний баримтын архивын цахимжуулалтаар 20561579 хуудас архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлж, цахимжуулалтын ажлын явц 88.05%-ийн гүйцэтгэлтэй явагдаж байна.</p> <p>Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн архивын нийт 4728956 хуудас баримтыг цахимжуулах ажил бүрэн дууссан.</p> <p>Иргэн, хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн нийт 41.532.680 хуудас баримт бичгийг цахимжуулсан байна.</p>			
4		3.Нийслэл, аймгийн төв, томоохон суурин газрын хаягийн бүртгэлийг шинэчлэн, шифр, кодын нэгдсэн тогтолцоог улсын хэмжээнд бий болгож, олон улсын жишигт хүрсэн хаягжуулалт, газар усны нэр, хаягийн нэгдсэн сантай болох	-	-	МШХХТГ УБЕГ	<p>УИХ-аас 2013 онд батлагдсан “Хаягжуулалтын тухай хууль”, Засгийн газрын 2013 оны 280 дугаар тогтоолоор батлагдсан “Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах журам”-ыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.</p> <p>Улсын бүртгэлийн байгууллагын хэмжээнд хаягийн нэгдсэн санг үүсгэн иргэн, хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байна. Сонгогчдын нэрийн жагсаалтыг хаягийн нэгдсэн санг үндэслэн үүсгэж байна.</p> <p>Сонгуулийн бэлтгэл ажлын хүрээнд иргэний бүртгэлийн хаягийн санг цэгцлэх, Монгол Улсын иргэний цахим үнэмлэхийн бичил санах ой /чип/-д хаягийн бичилт хийх, хаягийн давхардлыг арилгах ажлыг хийж байна.</p>	100%		
5		4.Бүртгэл, мэдээллийн тогтолцоог богино хугацаанд бүхэлд нь боловсронгуй болгох	-	-	МШХХТГ УБЕГ	<p><u>Иргэний бүртгэлийн чиглэлээр:</u></p> <p>Энэхүү ажлын хүрээнд иргэний шинэчилсэн бүртгэлийн ажлыг зохион байгуулж, Монгол Улсын иргэдийн биеийн давхцахгүй өгөгдлийн мэдээллийн санг үүсгэж, иргэний цахим үнэмлэхийг олгосон.</p> <p>Улсын хэмжээнд иргэний бүртгэлийн цахим мэдээллийн нэгдсэн санг үүсгэж, онлайн, офлайн програм хангамжийг нэвтрүүлэн аймаг, нийслэл, сум, дүүрэг, хорооны хэмжээнд эрхлэн хөтөлж байна.</p> <p>Иргэний бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулан Хууль зүйн</p>	100%		



					<p>боломжтой болно.</p> <p><u>Хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр:</u>  Хуулийн этгээдийн бүртгэлийн архивын баримтыг улсын хэмжээнд 100% цахим хэлбэрт шилжүүлэж, нийслэл болон 21 аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийг холбосон нэгдсэн сүлжээ, шинэ програм хангамжийг бий болгосон.</p> <p>Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдаж, 2015 оны 3 дугаар сарын 1-ний өдрөөс мөрдөгдөж эхэлсэнтэй холбогдуулан хуулийн этгээдийн мэдээллийг цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлэх портал сайт болон хуулийн этгээдийн нэрийг онлайнаар шинээр авах, хуулийн этгээдийг шинээр үүсгэн байгуулах, хуулийн этгээдийн мэдээлэлд нэмэлт өөрчлөлт оруулах, үйлчилгээний дарааллыг урьдчилан захиалах хүсэлт хүлээн авах, хуулийн этгээдийн гэрчилгээг онлайнаар харах агуулга бүхий үйлчилгээний вэб портал бий болгож, хэрэглээнд нэвтрүүлсэн.</p>			
--	--	--	--	--	---	--	--	--

**БИЕЛЭЛТИЙН ДУНДАЖ: 100%**

**УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР**